



MONGOLIAN A1 – STANDARD LEVEL – PAPER 1
MONGOL A1 – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1
MONGOL A1 – NIVEL MEDIO – PRUEBA 1

Tuesday 3 May 2005 (morning)

Mardi 3 mai 2005 (matin)

Martes 3 de mayo de 2005 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only. It is not compulsory for you to respond directly to the guiding questions provided. However, you may use them if you wish.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages. Le commentaire ne doit pas nécessairement répondre aux questions d'orientation fournies. Vous pouvez toutefois les utiliser si vous le désirez.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento. No es obligatorio responder directamente a las preguntas que se ofrecen a modo de guía. Sin embargo, puede usarlas si lo desea.

Доорх хоёр зохиолын хэсгийг уншаад, аль нэгийг сонгон тайлбарлаж бич. Хэрэв шаардлагатай гэж үзвэл зохиолын төгсгөлд буй удирдамж асуултын дагуу бичиж болно.

1. (a)

Дөрвөн Ойрадын хан Галдан бошигт өөрийн төрсөн охин Юнчихай, баруун гарын хөлөг их баатар Данжила хоёрын хамт амь биенээсээ ч илүү хайрлаж энхрийлдэг асан Ану хатангаа онголж оршуулсан газар дээр очоод буцаж явлаа.

5 Эмээл дээрээ жишүүхэн суугаад их дэлт цагаан шарга мориныхоо чихийг ширтэсхийн үг дуугүй бодлогошрон гэлдрүүлж явсан хантан хагацал зовлонг амсахаараа нэг амсаж, цөхрөнгөө барсан хүний алжаангуй, саарал дуугаар өгүүлэв.

10 - Хөх тэнгэрийн зарлигаар миний насны тоо гүйцжээ. Иймд би хатантны газар дахин ирж чадахгүй биз. Та хоёр талийгаачийн шарил дээр хаврын хөх ногооноор жилдээ нэг заавал ирж байгаарай гэж хэлээд зовхи нь цэлхрэн хавагнасан, гунигтай нүдээр эргэн харлаа. Хэдэн саахалтын чанадад тэнгэрийн одоор тэмдэг тавин онголсон Ану хатны гэрэлт хөшөө аглаг буйд, хээр талын явган зэрэглээнд өнчин янзага адил ганцаар бөртөлзөн үзэгдэнэ.

15 Хантны ядрангуй шарланги нүүр дээгүүр усны сэрүүн сүүдэр адил хэдэн бөртхөн хөх толбо навчин тодорхуй дор тэр нэгэнтээ хүндээр амьсгаллаа.

20 - Би Лхас, Түвдийн эрдэнийн гурван хийдийн хутагт хувилгаадын хүрэхүйеэ бэрх эрдмийн оргилд нэгэнт хүрч тэргүүн хамбын алтан сэнтийд залагдах ховорхон завшааныг хүртсэн хэдий боловч Ану хатнаас хүндтэй амин шүтээнийг орчлон ертөнц дээрээс олж бишрэн сүсэглэсэнгүй. Гэтэл миний бие цэргээ манжид гурвантаа хиар цохиулж, Дөрвөн Ойрадын гал голомт сахих хоёрын хоёр хүүгээ Бээжинд цаазлуулан толгойг нь хазлаа хэмээн намуухан боловч цухалдангуй өгүүлснээ гэнэт амь амьсгал нь давхцан багтарч зүрхээ дарлаа.

25 - Монголын газар шороог манж, хятадуудад алдвал амьд хүн байтугай үхсэн хүний яс ч үл амарна. Данжила, чи нүдээ хөдөлж байсан цагт харийн хар элэгтэнд алга дарам газар ч бүү өг. Ухаарав уу! Алга дарам газар ч ... гэж давтан тасалдангуй өгүүлээд мориныхоо дэлийг дэрлэн үхэтхийн уналаа.

30 Зүүнгарын Галдан бошигт ханы шарилыг түүний гэрээслэл ёсоор чандарлаж, хааш хаашаагаа таван ямхын хаш чулуун хайрцагт залж, Дөрвөн Ойрадын догшин хар сүлдний өмнө зааны ясан ширээн дээр тахьжээ. Барсын арьсаар зүйж оёсон их хөлгөн асарт арц хүжис, гүгэл зандангийн ариун дагшин үнэр сэнгэнэн, цэнхэр утаа намжааран суунаглах нь бурхадын орныг санагдуулам эрхэмсэг намуун ая эгшгийг хүний сэтгэлд хөглөх ажээ. 35 Ихэс дээдэс, лам нар, харц доодос цөм ханы чандрыг агуулсан мөнөөхөн хаш хайрцагнаас адис авч, амь насаа даатган, сүсэглэн залбирцгааж байтал гаднаас хоргой уужтай, царайлаг сэвгэр гүйн орж ирээд хүүхдийнхэрхүү цангинасан цовоо хоолойгоор:

40 - Тэнгэрт үүл бороо нэгээхэн бээр үгүй бөгөөтөл ижилгүй сайхан солонго татжээ. Энэ лавтай жир нэгэн, үзэгдэл биш. Сохор хүмүүн боловч гарч харцгаагтун гэж хашгирахад нүүр нүдэндээ хагацлын бараан сүүдэр унаган гашуудан зогссон хүмүүс цөм алчуур, малгайгаа шүүрэн авч гадагш гарцгаалаа. Тоос тортог нэгээхэн ч үгүй огторгуйн гэгээн мандалд нүдгүй амьтан ч сургаар нь дуу алдаж бишрэн баясмаар, цээжний харанхуй 45 бүрэнхийг гэрэлтүүлсэн, босоо цагаан солонго татжээ. Түүнийг харсан лам хуврагууд алга хавсран сүсэглэн залбирах зуураа гайхаж алмайрсан олонд хандаж:

50 -Хүүхдүүд минь, сөгдөн мөргөцгөө! Тэнгэрийн хөвгүүн хутагт ханы сүнс орчлонгийн тоосноос тасарч огторгуйд огшиж байна. Бурхан хутагтын эрдэм номын гэрэл гэгээнд залбирцгаагтун! гэхэд тэнд хуран чуулсан олон хүн нэгэн зэрэг сөгдөн мөргөцгөөлөө....

Б.Догмид “Ялгуусан хутагтын дууль өгүүллэг, “Хөх тэнгэрийн зарлиг” УБ 1996 номоос

- Энэ зохиолын хэсгийн агуулга юу вэ?
- Зохиолын энэхүү хэсгийн утга санааг зохиолч хэрхэн илэрхийлсэн бэ?
- Зохиолын хэсэгт Галдан бошигт хэмээх энэ их хүмүүний амьдралыг хэрхэн дүрсэлсэн бэ?
- Энэхүү зохиолын хэсгийг уншаад төрсөн сэтгэгдлээ бич.

1. (b)

Дэвтэр дүүртэл ноороглосон
Дэврүүн сэтгэлтэй мөчлөгүүдийнхээ
Эхний халуун өдрүүдийг
Эх орон таньдаа би зориулсан шүү
5 Уул бүхнийхээ нэрийг багтааж
Ус болгоныхоо урсгалыг сонсгоё гэж
Дэлбээ цаасан дээр
Үзэг хурдлахгүй сульдаж
Дэврүүхэн онгодоос минь
10 Үг багтахгүй асгарсаан
Сайхан эх орноо
Санаандаа энхрийлэх ч жаргалтай юм билээ
Бадаг болгондоо олзуурхаж
Байн байн унших ч азтай юм билээ
15 Өчнөөн шад тэрлэж суухдаа
Өөрийгөө би голоогүй ээ
Нэгэн дэвтэр шүлгийнхээ ард
Нэрээ тавихдаа би ичээгүй ээ
Мөр болгонд нь хайр үнэн
20 Мөрөөдөл хүсэл бахдал шингэсэн
Анхны урам “шүлгэн хайраа”
Алдарт найрагчид уншиж бэрэвшихэд
“Эвлэж арай болоогүй байна даа” гэж
Үгний суудал сольсноос биш
25 Эх орон ийм байдаггүй юм гэж
Үнэндээ намайг зэмлээгүй шүү
Нутаг ус минь ээ!

Ш. Гүрбазар “Эх орон” шүлэг, “Дугуй хээтэй наадам” УБ 1991 номоос

- Энэ зохиолын агуулга, утга санаа юу вэ?
- Эх орон гэдэг хүний амьдралд ямар үүрэгтэй вэ?
- Уран дүрслэлийн ямар аргуудыг хэрхэн хэрэглэснийг тайлбарла.
- Энэхүү шүлгийг уншаад ямар сэтгэгдэл төрсөн тухайгаа бич.